

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/1/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn	Санхүүгийн аудитын газрын захирал,
Улаанбаатар хот	Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
2025 он	Утас: 261663,
	Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
	Аудитын менежер: П.Чанцалдулам
	Утас: 261885
	Цахим хаяг: chantsaldulamj@audit.gov.mn
	Аудитор: Г.Тэлмүүн
	Утас: 261885
	Цахим хаяг: telmuung@audit.gov.mn
	Грант Торнтон аудит ХХК-ийн
	Гүйцэтгэх захирал: О.Идшинринжин
	Утас: 99993795
	Цахим хаяг: info@mn.gt.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсөв, гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Албан шаардлага.....	19
5.2 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ЕХОБ	Европын хөрөнгө оруулалтын банк
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТХН	Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УАНС	Уур амьсгалын ногоон сан
СЗЗ	Санхүүгийн зуучлалын зээл
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026 04 02 № 06/310
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

2024 оны 11 дүгээр сарын 5-аас 15-ны хооронд ажилласан Азийн хөгжлийн банкны томилолтын үеэр 2023 оны 3 дугаар сарын 22-нд батлагдсан Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны (1, 2, 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийг хамарсан) худалдан авах ажиллагааны анхны төлөвлөгөөнд тодотгол хийсэн байна.

Азийн хөгжлийн банктай хийсэн нарийвчилсан хэлэлцээрийн үр дүнд худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөг 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр баталсан байна. Шинэчилсэн төлөвлөгөөний дагуу 1 дүгээр үе шатны төслийн худалдан авалт 79 багцаас бүрдэх бөгөөд эдгээрийн хүрээнд 147.1 сая ам.долларын үнийн дүнтэй 87 гэрээ байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнд: 43 ажлын гэрээ, 9 бараа үйлчилгээний гэрээ, 7 олон талт гэрээ, 7 зөвлөх үйлчилгээний фирмийн гэрээ, 4 хувь зөвлөх үйлчилгээний гэрээ, 1 үйлдвэрийн гэрээ, мөн төслийн нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил худалдан авах 16 гэрээ тус тус багтсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журамд төслийн хүрээнд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийг хэрхэн нягтлан бодох бүртгэлд хүлээн зөвшөөрөх, тайлагнах талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй тул төсөл хэрэгжүүлэх нэгж нь татварын чөлөөлөлтийг зарим тохиолдолд үндсэн хөрөнгийн өртөгт шингээж, зарим тохиолдолд орлого болон өмчийн өөрчлөлтөөр бүртгэж тайлагнаж байсан. Харин 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/З тоот тушаалаар журмыг шинэчлэн баталж, Монгол Улсын Засгийн газраас олон улсын гэрээний хүрээнд гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд үзүүлсэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн дүнг хөрөнгийн өртөг болон хөнгөлөлт чөлөөлөлтийн орлогоор хүлээн зөвшөөрөхгүй байх талаар тодорхой зааж өгсөн байна.

Дээрх журмын шинэчилсэн зохицуулалтыг 2024 оны бүртгэлтэй харьцуулан үнэлэхэд нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийг үндсэн хөрөнгийн өртөгт шингээж бүртгэсэнтэй холбоотойгоор хөрөнгө болон хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдлийг илүү илэрхийлэгдсэн, мөн гааль, нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг өмнөх онд санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор, тайлант хугацаанд 77,307.2 мянган төгрөгийг өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капиталаар бүртгэж тайлагнасан нь тайлан хоорондын логик уялдааг алдагдуулсан байна.

Бусад асуудал

Төслийн удирдах хорооны 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 2025/02 тоот тогтоолын хавсралтаар Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Үйл ажиллагааны төлөвлөгөө болон Санхүүжилтийн төлөвлөгөөг тус тус баталсан.

Батлагдсан 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нийт 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Тайлант оны жилийн эцсийн байдлаар тасралтгүй хэрэгжих менежмент, зохион байгуулалтын 12 арга хэмжээ хэрэгжсэн бол 13 арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна. Мөн 27 арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг 2026 он, 2028 он руу шилжүүлэх болсон тул төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	339,398,947.62	1,039,229,592.49
31	Мөнгөн хөрөнгө	331,382,947.62	1,019,473,592.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	331,382,947.62	1,019,473,592.49
3121	төгрөг	49,932,045.83	115,188,377.23
31211	Төрийн сангийн харилцах	49,932,045.83	115,188,377.23
3122	Гадаад валют	281,450,901.79	904,285,215.26
31221	Төрийн сангийн харилцах	281,450,901.79	904,285,215.26
33	Авлага	8,016,000.00	19,756,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,000.00	-
335	Бусад авлага	8,012,000.00	19,756,000.00
3351	Байгууллагаас авах авлага	7,996,000.00	19,756,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	16,000.00	-
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	823,455,317.50	651,627,144.80
39	Үндсэн хөрөнгө	823,455,317.50	651,627,144.80
392	Биет хөрөнгө	780,565,317.50	620,807,599.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	566,000,000.00	514,545,454.54
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,150,000.00)	(64,318,181.81)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	163,853,300.00	148,957,545.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,211,830.00)	(42,711,354.56)
39207	Тавилга,аж ахуйн эд хогшил	83,063,000.00	75,511,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,989,152.50)	(11,177,684.36)
393	Биет бус хөрөнгө	42,890,000.00	30,819,545.50
39301	Програм хангамж	47,464,000.00	44,058,181.78
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,574,000.00)	(13,238,636.28)
3	Нийт хөрөнгийн дүн iii=i+ii	1,162,854,265.12	1,690,856,737.29
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,162,854,265.12	1,690,856,737.29
512	Хуримтлагдсан үр дүн	1,162,854,265.12	1,690,856,737.29
51210	Өмнөх үеийн үр дүн	-	1,162,854,265.12
51220	Тайлант үеийн үр дүн	1,162,854,265.12	528,002,472.17
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,162,854,265.12	1,690,856,737.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны орлогын дүн	2,090,364,049.25	2,743,148,997.20
12	Татварын бус орлого	2,090,364,049.25	2,743,148,997.20
120	Нийтлэг татварын бус орлого	2,090,364,049.25	2,743,148,997.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,090,364,049.25	2,743,148,997.20
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих I4307	2,003,341,955.12	2,743,148,997.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,022,094.13	-
2	Үйл ажиллагааны зардлын дүн	934,558,489.51	2,173,270,570.93
21	Урсгал зардал	934,558,489.51	2,173,270,570.93
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	934,558,489.51	2,173,270,570.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	603,723,445.13	1,391,704,259.55
210101	Үндсэн цалин	603,723,445.13	1,391,704,259.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,528,623.89	160,652,999.20
210201	Тэтгэврийн даатгал	51,719,137.82	110,815,447.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,084,604.44	14,081,511.05
210203	Үөмшө-ний даатгал	3,233,597.23	7,213,705.59
210204	Ажилгүйдлийн даатгал	2,479,292.89	5,720,267.11
210205	Эрүүл мэндийн даатгал	10,011,991.51	22,822,068.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,669,645.75	167,181,679.00
210301	Гэрэл, цахилгаан	355,621.20	1,213,179.00
210304	Байрны түрээс	92,314,024.55	165,968,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,398,507.96	37,862,634.95
210401	Бичиг хэрэг	11,790,900.00	12,710,187.42
210402	Тээвэр, шатахуун	18,004,499.96	18,784,846.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,603,108.00	6,367,601.08
2107	Томилолт, зочны зардал	74,796,792.99	52,236,354.00
210702	Дотоод албан томилолт	74,796,792.99	52,236,354.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,268,091.29	269,111,769.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,640,740.30	249,646,277.72
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		10,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,574,224.00	8,746,608.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,883,466.99	454,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	169,660.00	264,884.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,173,382.50	94,520,874.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	248,400.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,924,982.50	94,520,874.51
3	Үйл ажиллагааны үр дүн	1,155,805,559.74	569,878,426.27
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн	7,048,705.38	35,431,344.09
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	7,048,705.38	35,431,344.09
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн дүн	7,048,705.38	35,431,344.09
225005	унэ төлбөргүй гарсан зардал		77,307,298.19
4	Үйл ажиллагааны бус үр дүн	7,048,705.38	(41,875,954.10)
5	Нийт үр дүн	1,162,854,265.12	528,002,472.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,003,341,955.12	2,743,148,997.20
12	Татварын бус орлого	2,003,341,955.12	2,743,148,997.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,003,341,955.12	2,743,148,997.20
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих I4307	2,003,341,955.12	2,743,148,997.20
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,164,462,258.34	2,090,489,696.42
21	Урсгал зардал	1,164,462,258.34	2,090,489,696.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	603,723,445.13	1,391,700,259.55
210101	Үндсэн цалин	603,723,445.13	1,391,700,259.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,528,623.89	160,652,999.20
210201	Тэтгэврийн даатгал	51,719,137.82	110,815,447.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,084,604.44	14,081,511.05
210203	Үөмшө-ний даатгал	3,233,597.23	7,213,705.59
210204	Ажилгүйдлийн даатгал	2,479,292.89	5,720,267.11
210205	Эрүүл мэндийн даатгал	10,011,991.51	22,822,068.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,787,992.00	178,941,679.00
210301	Гэрэл, цахилгаан	323,292.00	1,213,179.00
210304	Байрны, зогсоолын түрээс	95,464,700.00	177,728,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,884,734.51	37,862,634.95
210401	Бичиг хэрэг	10,719,000.00	12,710,187.42
210402	Тээвэр, шатахуун	16,531,363.60	18,784,846.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,634,370.91	6,367,601.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	268,527,547.27	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	193,015,727.27	-
210602	Тавилга	75,511,820.00	-
2107	Томилолт, зочны зардал	73,629,918.00	52,236,354.00
210702	Дотоод албан томилолт	73,629,918.00	52,236,354.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,138,097.54	269,095,769.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,420,740.30	249,630,277.72
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	10,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,703,840.00	8,746,608.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,843,857.24	454,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	169,660.00	264,884.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,900.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	241,900.00	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	838,879,696.78	652,659,300.78
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	514,545,454.54	-
222001	Тоног төхөөрөмж	514,545,454.54	-
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(514,545,454.54)	-
7	Санхуугийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гйлгээ		
14	Бусад эх үүсвэр	7,048,705.38	35,431,344.09
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	7,048,705.38	35,431,344.09
7	Санхуугийн уйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	7,048,705.38	35,431,344.09
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	331,382,947.62	688,090,644.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	331,382,947.62
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	331,382,947.62	1,019,473,592.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлтыг	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	1,162,854,265.12	1,162,854,265.12
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,162,854,265.12	1,162,854,265.12
D05	Татварын хөнгөлөлт	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	528,002,472.17	528,002,472.17
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,690,856,737.29	1,690,856,737.29

2.5 Аудит хийсэн төсөв, гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,215,580,000.00	2,090,489,696.42	125,090,303.58	94%
УРСГАЛ ЗАРДАЛ	2,215,580,000.00	2,090,489,696.42	125,090,303.58	94%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,215,580,000.00	2,090,489,696.42	125,090,303.58	94%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,444,000,000.00	1,391,700,259.55	52,299,740.45	96%
Үндсэн цалин	1,444,000,000.00	1,391,700,259.55	52,299,740.45	96%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,500,000.00	160,652,999.20	19,847,000.80	89%
Тэтгэврийн даатгал	122,740,000.00	110,815,447.00	11,924,553.00	90%
Тэтгэмжийн даатгал	14,440,000.00	14,081,511.05	358,488.95	98%
ҮОМШӨ-ний даатгал	7,220,000.00	7,213,705.59	6,294.41	100%
Ажилгүйдлийн даатгал	7,220,000.00	5,720,267.11	1,499,732.89	79%
Эрүүл мэндийн даатгал	28,880,000.00	22,822,068.45	6,057,931.55	79%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,880,000.00	178,941,679.00	3,938,321.00	98%
Гэрэл, цахилгаан	1,330,000.00	1,213,179.00	116,821.00	91%
Байрны түрээс	181,550,000.00	177,728,500.00	3,821,500.00	98%
Хангамж, бараа материалын зардал	41,400,000.00	37,862,634.95	3,537,365.05	91%
Бичиг хэрэг	15,270,000.00	12,710,187.42	2,559,812.58	83%
Тээвэр, шатахуун	19,630,000.00	18,784,846.45	845,153.55	96%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,500,000.00	6,367,601.08	132,398.92	98%
Томилолт, зочны зардал	55,300,000.00	52,236,354.00	3,063,646.00	94%
Дотоод албан томилолт	55,300,000.00	52,236,354.00	3,063,646.00	94%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	311,500,000.00	269,095,769.72	42,404,230.28	86%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	291,735,000.00	249,630,277.72	42,104,722.28	86%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	10,000,000.00	-	100%
Даатгалын үйлчилгээ	9,000,000.00	8,746,608.00	253,392.00	97%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	454,000.00	46,000.00	91%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	265,000.00	264,884.00	116.00	100%
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	0%
Барилга байгууламж	-	-	-	0%
Тоног төхөөрөмж	-	-	-	0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,743,148,997.20	2,743,148,997.20	-	100%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,743,148,997.20	2,743,148,997.20	-	100%
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,743,148,997.20	2,743,148,997.20	-	100%
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-	-	0%
Хандив тусламж /гадаад/	-	-	-	0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	331,382,947.62	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,019,473,592.49	-	-
Ажиллагсдын тоо	41	38	3	92%
Удирдах ажилтан	5	5	-	100%
Гүйцэтгэх ажилтан	32	30	2	92%
Үйлчлэх ажилтан	4	3	1	92%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, хүн ам амьдрахад таатай хот, суурин газар (аймаг, сумын төв)-ыг байгуулж, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх, орон нутгийн ногоон хөгжлийн загвар, шинэчлэлийг хөхүүлэн дэмжих, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлэх зорилготой бөгөөд дараах 4 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжинэ. Үүнд:

- Бүрэлдэхүүн хэсэг 1: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгч бага ялгаруулдаг, хүн ам суурьших аймаг болон сумын төвүүдийг хөгжүүлэх;
- Бүрэлдэхүүн хэсэг 2: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлттэй, тогтвортой бэлчээр болон хөдөө аж ахуйн менежментийг хэрэгжүүлэх;
- Бүрэлдэхүүн хэсэг 3: Нүүрстөрөгч бага ялгаруулдаг, уур амьсгалд тэсвэртэй малын болон агро-бизнесийн өртгийн сүлжээг бий болгох хүртээмжтэй санхүүжилт олгох;
- Бүрэлдэхүүн хэсэг 4: Нүүрстөрөгч бага ялгаруулдаг, уур амьсгалд тэсвэртэй агро бүс нутгийн хөгжлийг хангах институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх.
- Уг хөтөлбөр нь “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн хүрээнд Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, “Ковид-19” цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх, ногоон хөгжлийг дэмжих зорилтуудтай нийцсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан чиглэлүүд болон хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдаж хүнсний нийлүүлэлтийн сүлжээ, тогтолцоо, хүнсний аюулгүй байдлыг хангах, хот хөдөөгийн уялдаа холбоог дэмжих, аймаг, сумын төвүүдэд хүн амьдрахад таатай орчныг бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох ногоон, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх үндэс болох юм.

Хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк (АХБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС) болон Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)-ны нэн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн 10 жилийн хугацаатай олон шатлалт санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн 1, 2, 3 дугаар үе шатны төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт санхүүжилт 735.0 сая ам.доллар байх ба үүнээс Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төсөлд нийт 270.0 сая ам.долларын гэрээ байгуулагдсан.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 4 тоот тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдөж ажиллаж байна. Журмын 1.2-т журмыг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Өрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;

**“Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны А/03 тоот тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, тусгай гүйцэтгэсэн ажлын талаар судлах, танилцаж гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаанд зохих байдалтай, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 тоот тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 528,002.5 мянган төгрөгөөр буюу 45 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	331,383.0	1,019,473.6	688,091.6
Авлага	8,016.0	19,756.0	11,740.0
Үндсэн хөрөнгө	823,455.3	651,627.1	(171,828.2)
Нийт хөрөнгө	1,162,854.3	1,690,856.7	528,002.4
Хуримтлагдсан ашиг	1,162,854.3	1,690,856.7	528,002.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,162,854.3	1,690,856.7	528,002.4

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг, алдагдлын дансдууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө 688,091.6 мянган төгрөгөөр өссөн нь Улсын Их Хурлын 2024 оны 81 тоот тогтоолоор гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүн, үр ашигт дүн шинжилгээ хийх, гадаад зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зардлыг цаашид санхүүжүүлэхгүй байх чиглэл дагуу Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 01/10803 тоот албан бичгээр 2025 онд хэрэгжих гадаад зээлийн төслүүдийн үр ашиг, ач холбогдлоор нь

“Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

эрэмбэлж зарим шаардлагагүй шинэ худалдан авалт болон зарим зөвлөх үйлчилгээний гэрээний санхүүжилтийг зогсоох, хойшлуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төлөвлөж ажиллах чиглэл өгсөнтэй холбогдуулан төслийн зөвлөх үйлчилгээний

зардлын биелэлт 86 хувьтай гүйцэтгэгдсэн мөн зээлийн гэрээний дагуу тайлант хугацаанд ногдох санхүүжилт өмнөх оноос их орж ирснээс шалтгаалсан байна.

Авлага 11,740.0 мянган төгрөгөөр өссөн нь оффисын түрээсийн өмнөх гэрээ цуцлагдаж Эко пропертиз ХХК-тай 2025 оны 11 сарын 19-ны өдөр 1 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулж гэрээний дагуу барьцаа төлбөр төлж авлагаар бүртгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 171,828.2 мянган төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Засгийн газраас олон улсын гэрээний хүрээнд гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд үзүүлсэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын дүн болох 77,307.2 мянган төгрөгийг хөрөнгийн өртөгт оруулан тайлагнасан мөн тайлант хугацааны элэгдлийг зардлыг 94,520.8 мянган төгрөгөөр тооцож бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Хуримтлагдсан ашиг 528,002.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс хамаарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээлийн эх үүсвэрээс 2,215,580.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийт зардлын төсвийн төсөлд цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 1,444,000.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 180,500.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 182,880.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 41,400.0 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 55,300.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 311,500.0 мянган төгрөгөөр нийт 2,215,580.0 мянган төгрөгөөр зардлын төсөв хүргүүлж батлуулсан байна. Тайлант хугацаанд төсөвт тодотгол хийгдээгүй байна.

Гүйцэтгэлээр 2,743,418.9 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн ба тайлант хугацаанд 2,090,489.6 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч үлдэгдэл 652,929.3 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	Хөтөлбөр арга хэмжээний төсөв, гүйцэтгэл 70705	2,215,580.0	2,090,489.6	125,090.4	94%
Дүн		2,215,580.0	2,090,489.6	125,090.4	94%

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус

байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

- 2024 оны эцсийн байдлаар төслийн нэгжид АХБ-ны журмын дагуу 23 ажилтныг нээлттэй сонгон шалгаруулалтаар авч томилсноос 6 ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн, 2025 онд шинэ ажлын байранд 12 ажилтан, нөхөн сонгон шалгаруулалтаар 13 ажилтныг тус тус томилсон, 10 ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар нэгдсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 32 ажилтантай, ажлын байрны сул орон тоо 7 байгаатай холбогдуулан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардлаас 52,299.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 19,847.0 мянган төгрөгийг зарцуулаагүй,
- 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар Пропертик ХХК-тай оффисын түрээсийн гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан ба Тайлант хугацаанд гэрээний хугацааг дахин 1 жилээр сунгаж түрээсийн гэрээ байгуулсан боловч 2025 оны 09 сарын 11-ний өдөр түрээсийн гэрээг цуцлах мэдэгдэл ирүүлж гэрээг цуцалж оффисын байр солигдсонтой холбоотой байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 3,938.3 мянган төгрөгийг зарцуулаагүй,
- Тайлант хугацаанд бичиг хэрэг болон шатахууны зардал бага гарсантай холбогдуулан хангамж, бараа материалын зардлаас 3,537.3 мянган төгрөгөөр зарцуулаагүй,
- Төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтыг баталгаажуулах, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн барилга, хот байгуулалт болон нүүлгэн шилжүүлэлт хариуцсан мэргэжилтнүүд Ховд, Баян-Өлгий, Увс аймагт орон нутгийн удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийхэд 11,790.3 мянган төгрөг, мөн дээрх аймгуулын 16 суманд аймаг, сумын удирдлага, Хүнс, хөдөө аж ахуйн газар, газрын даамал, бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтнүүд, малчдын төлөөллийг хамруулан уулзалт, яриа танилцуулга зохион байгуулахад 40,446.0 мянган төгрөгийг тус тус томилолтын зардалд зарцуулж 3,063.6 мянган төгрөгийн зарцуулаагүй байна.
- Монгол улсын сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 01/10803 дугаар чиглэлээр гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүн, үр ашигт дүн шинжилгээ хийх, гадаад зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх чиглэл өгсөнтэй холбогдуулан бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжын зардлаас 42,404.2 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд тайлант оны жилийн эцсийн байдлаар тасралтгүй хэрэгжих менежмент, зохион байгуулалтын 12 арга хэмжээ, хэрэгжиж дууссан 13 арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна. Хэрэгжилт удаашралтай болон хэрэгжүүлж амжаагүй арга хэмжээг 2026-2028 онд шилжүүлж, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн байна.

**“Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Бүрэлдэхүүн хэсэг/ Бараа, ажил, үйлчилгээний нэр	Батлагдсан төсөвт өртөг		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	
		Үндсэн валют	Төгрөг	Үндсэн валют	Төгрөг
1	2	2	3	4	5
I.	Бүрэлдэхүүн I				
a.	"Нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтад хяналт тавих" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	7,035.3	24,062,809.7	-	-
b.	"Төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг бодлогыг сайжруулах " зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	4,346.0	14,864,406.5	-	-
c.	Увс аймгийн Өмнөговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах	150.0	513,037.5	-	-
II.	Бүрэлдэхүүн II				
a.	"Үр дүн 2-ын төслийн хэрэгжилтийн техникийн туслалцаа" (үүнд бэлчээрийн менежмент, усжуулалтын систем, малын үржил, мал эмнэлгийн үйлчилгээ, гэрчилгээжүүлэлтийн дэмжлэг бодлогыг дэмжих) зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	6,198.5	21,200,488.0	-	-
III.	Бүрэлдэхүүн III				
a.	"Үр дүн 3-ын төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг" (ногоон ХАА-н бизнест зориулсан санхүүгийн зуучлалын зээл) зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	2,700.0	9,234,675.0	-	-
	Нийт дүн	20,430	69,875,417	-	-

(1.a) Тендер 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр АХБ-ны www.cms.adb.org, төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn, ЭЗХЯ-ны www.med.gov.mn цахим хуудсуудаар 30 хоногийн хугацаатай олон нийтэд, нээлттэй зарлагдсан. Тендерт оролцогчоос Сонирхлоо илэрхийлэх хүсэлт хүлээн авах эцсийн хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 23-нд дууссан ба 21 компани тендерт оролцох саналаа АХБ-ны цахим системээр ирүүлсэн. Үнэлгээний хорооны хураангуй жагсаалтын зөвлөмжийг (Submission-1) Захиалагчийн зөвшөөрлөөр 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр АХБ-д илгээсэн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр АХБ-наас зөвшөөрөл үл татгалзах хариу ирүүлсэн. Үнэлгээний хорооноос 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Захиалагчид саналын баримт бичиг олгох зөвшөөрлийг хүргүүлсэн бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 23, 24, 30-ны өдрүүдэд үнэлгээний хороо хуралдаж техникийн саналын үнэлгээг эцэслэн дуусгасан ба 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр техникийн саналын үр дүнг (Submission-2) АХБ-нд илгээсэн. АХБ-наас хариу хүлээж байна.

(1.b) 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдөр богино жагсаалтад орсон тендерт оролцогч нарт санал авах хүсэлтийн баримт бичгийг олгосон бөгөөд санал хүлээн авах эцсийн хугацаа болох 2025 оны 04 дүгээр сарын 30-нд битүүмжилсэн санал хүлээн авч, техникийн саналын

үнэлгээний тайланг 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдөр бэлтгэж, захиалагчийн зөвшөөрлөөр 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр АХБ-д хүргүүлж, АХБ-аас 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдөр зөвшөөрөл ирүүлсэн. Шалгарсан оролцогчтой гэрээний хэлцэл 4 удаа хийж улмаар гэрээний драфт бэлдэж АХБ-аар гэрээний хэлцэлтэй холбоотой баримт бичгийг хянуулж, зөвшөөрөл авахаар илгээсэн. 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр АХБ-аас гэрээний төсөлд үл татгалзах мэдэгдлийг ирүүлсэн бөгөөд 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр гэрээг батлуулахаар ЭЗХЯ-нд хүргүүлээд байна.

(1.с) Ажлын даалгавар (TOR)-ыг бэлтгэж АХБ-руу хянуулахаар явуулсан. Үнэлгээний хороо байгуулах хүсэлтээ ЭЗХЯ-нд хүргүүлсэн.

(2.а) Тендер 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр АХБ-ны www.cms.adb.org, төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn, ЭЗХЯ-ны www.med.gov.mn цахим хуудсуудаар 30 хоногийн хугацаатай олон нийтэд, нээлттэй зарлагдсан. 2025 оны 05 дшээр сарын 23-нд АХБ-нд зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. АХБ-наас тодруулга, тайлбар авахаар албан бичиг ирүүлсэн ба тус тодруулгад хариу өгөх ажлын хүрээнд үнэлгээний хороо нийт 5 удаа танхим болон цахим хэлбэрээр хуралдаж, 2025 оны 08 дугаар сарын 18-нд ирүүлсэн тодруулгад хүргүүлсэн байна.

(3.а) “Ди би Эм ассет менежмент” ХХК-ийг сангийн менежмент хийх компаниар сонгон АХБ-аас үл татгалзах зөвшөөрөл авах тухай хүсэлтийг Сангийн Яам-д хүргүүлсэн. Сангийн сайдаас 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01/1069 тоот бичгээр “Ди Би Эм Ассет Менежмент” ХХК-ийг сангийн менежмент хийх компаниар ажиллуулахад татгалзах зүйлгүй тухай хариуг ирүүлж, Сангийн менежерээр Хөгжлийн банкны “Ди Би Эм Ассет Менежмент” ХХК-ийг томилох зөвшөөрлийг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Сангийн яаманд ирүүлснээр төслийн зөвлөх сонгон шалгаруулах нөхцөл бүрдсэн. Үүний дагуу сангийн менежер Хөгжлийн банкны зөвлөхийн ажлын даалгаварт санал авахад 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн 03/93 тоот албан бичгээр тус компани нь ижил төрлийн сан буюу АХБ-ны санхүүжилттэй “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан”-г үүсгэн байгуулсан туршлагадаа тулгуурлан GIRAF санг үүсгэн байгуулахдаа Time based гэрээнд суурилсан зөвлөх үйлчилгээний баг сонгон шалгаруулж хамтран ажиллах нь зардал өндөртэй, үр ашиг багатай байх тул хувь зөвлөх сонгон шалгаруулж ажиллах нь оновчтой бөгөөд зардал хэмнэх саналыг ирүүлсэн ба одоогоор хувь зөвлөх авах асуудлыг Төслийн удирдах хорооны хуралдаанд танилцуулахаар бэлтгэл ажлыг хангасан байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол Улсын Засгийн газар болон АХБ хооронд 2023 онд байгуулсан Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хавсралт баримт бичиг болох Хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлага, АХБ-ны баталсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Төслийн удирдах хорооны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 25/02 дугаар тогтоолоор баталсан Төслийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд зарлагдах 2,700.0 мянган ам.доллар төсөвт өртөгтэй, РИОЗ багцын дугаартай “Санхүүгийн зуучлалын зээлийн бүрэлдэхүүн хэсгийн төслийн хэрэгжилт болон менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажил”-ын тендерийг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төслийн удирдах хорооны 2025 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн хурлаар төслийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан бөгөөд Азийн Хөгжлийн банкнаас Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 3 дугаар сарын 21-нд шинэчилсэнтэй холбогдуулан төслийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2025 оны 3 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 56.8 хувьтай байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2024 онд худалдан авах ажиллагааны хүрээнд хувь зөвлөхийн 503,070.0 мянган төгрөгийн 4 гэрээ, төслийн үйл ажиллагаанд зориулсан оффисын тоног төхөөрөмж, програм хангамж, тавилга, тээврийн хэрэгсэл нийлүүлэлтийн 860,380.3 (НӨАТ орсон дүн) мянган төгрөгийн 7 гэрээ тус тус байгуулсан. Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөх үйлчилгээний фирмийн 6 тендер сонгон шалгаруулалт зохион байгуулсан ба гэрээ байгуулагдаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Грант Торнтон Аудит ХХК-ийн аудитор Б.Эрдэнэболд, туслах аудитор Х.Дүүрэнжаргал нар гүйцэтгэж, аудитын менежер Л.Болорцэцэг, чанарын хяналтын партнер Н.Эрдэнэцог, гэрээт ажлын партнер Б.Идшинринжин нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 11/174 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгосон., материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,196,863.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 21,968.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч нэгж нь зайлшгүй шаардлагатайгаас бусад оффисын тавилга эд хогшил худалдан авах зардлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, тус хуулиар хязгаарласан зардлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нэгж нь зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж ажилласан эсэхэд горим сорил хэрэгжүүлж холбогдох анхан шатны баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл болон шийдвэрүүдийг шалган үнэлэхэд зөрчил илрээгүй бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шаардлагыг зохих түвшинд мөрдөн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг шалгахад мэдээлэх үүрэгтэй Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв төлөвлөгөөний гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад, тендер, худалдан авалттай холбоотой таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 4,775,629.2 мянган төгрөгийн орлого, зарлагын 226 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд ил тод, бүрэн байршуулсан байна.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад шийдвэрийн биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,256.5	1	2,256.5	100
Зөвлөмж	2	33,172.7	2	33,172.7	100
Нийт дүн	3	35,429.2	3	35,429.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны санхүүгийн төлөвлөгөөний биелэлт 16 хувьтай байна. 2025 онд сонгон шалгаруулахаар төлөвлөсөн зөвлөх үйлчилгээний 5 тендерийн шалгаруулалтын хэрэгжилт тодорхой шалтгаанаар удааширснаас 2025 онд төсөвлөсөн санхүүжилтүүд хийгдээгүй тул дараагийн аудитаар тус зөвлөх үйлчилгээний тендер сонгон шалгаруулалт, үр дүнтэй бодитой холбогдох хууль, дүрэм журмын дагуу явагдсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 98,782.0 мянган төгрөгийн 2 алдааг¹ залруулсан.

Залруулсан алдаа:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 тоот тушаалаар шинэчлэн баталсан журмаар гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд үзүүлсэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн дүнг хөрөнгийн өртөг болон хөнгөлөлт чөлөөлөлтийн орлогоор хүлээн зөвшөөрөхгүй байх талаар тодорхой зааж өгснөөр нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийг үндсэн хөрөнгийн өртөгт шингээж бүртгэсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгийн үлдэгдэл 77,307.2 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 3,311.3 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн, мөн гааль, НӨАТ-ын нийт 87,022.0 мянган төгрөгийн чөлөөлөлтийг өмнөх онд санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор, тайлант хугацаанд 77,307.2 мянган төгрөгийг өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капиталаар бүртгэж тайлагнасан;
- Оффисын түрээсийн өмнөх гэрээ цуцлагдаж Эко пропертиз ХХК-тай 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр 1 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулж гэрээний дагуу 11,760.0 мянган төгрөгийн барьцаа төлбөр төлсөн боловч барьцаа төлбөрийг дансны авлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй.

Дээрх алдаа нь УСНББОУС 1 санхүүгийн тайлангийн толилуулга стандарт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 41,931.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 34,155.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 7,776.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 41,931.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 19,932.3 мянган төгрөгөөр давсан боловч уг зөрчлүүдийн шинж чанар, нөлөөллийг харгалзан үзэхэд санхүүгийн тайланг бүхэлд нь буруу илэрхийлэхүйц материаллаг зөрчил биш тул өөрчлөлтгүй санал дүгнэлт өгөв.

5.1 Албан шаардлага

5.1.1 Бүтэц, орон тоотой холбоотой

Илрүүлэлт 1:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь баланст 2 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байхад Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 210 тоот тушаалаар төслийн бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа жолоочийн орон тоог 3 байхаар тогтоосон нь ажлын ачаалал, хэрэгцээ шаардлагад нийцээгүй шийдвэр болсон байна. Тайлант хугацааны жолооч нарын ажлын гүйцэтгэлийг шалгахад 1 дүгээр жолооч 22 хоног, 2 дугаар жолооч 3 хоног, 3 дугаар жолооч 30 хоног албан томилолтоор ажилласан гэж жолоочийн тооцооны хуудсанд тусгасан боловч албан томилолтоос бусад өдрүүдэд авто тээврийн хэрэгслийг ашиглан үүргээ гүйцэтгэсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Гэтэл тайлант хугацаанд нийт ажлын 251 өдрийг бүтэн ажилласнаар тооцон цалин олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох," Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 11 дүгээр зүйл 11.1.3-т "төсвийн зарлагын норм,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

норматив болон төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг тогтоох” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, жолооч нарын ажлын гүйцэтгэлийг авто тээврийн хэрэгслийн ашиглалтын бүртгэл, замын хуудас, ажилласан цагийн бүртгэл, бодит гүйцэтгэлтэй уялдуулан цалинжуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Илүү жолооч ажилласантай холбоотой

Илрүүлэлт 2:

Ажлын байрны бодит хэрэгцээ шаардлага тодорхойгүй илүү жолооч ажиллуулснаас 30,360.0 мянган төгрөгийн цалингийн зардал, 3,795.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нийт 34,155.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гарган төсвийн сахилга бат алдагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т “үнэн зөв байх”, 6 дугаар зүйл 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 26.2-т “Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

Илүү жолооч ажиллуулсан зөрчлийг таслан зогсоож, цаашид жолоочийн орон тоог дахин хянаж, бүтэц орон тоог оновчтой тодорхойлох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

5.2.1 Аккруэл бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд хамаарах үйл ажиллагааны зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний нийт 440,920.1 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулан хуримтлуулж бүртгэлгүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь зардал хэзээ үүссэн, хэнээс авсан, ямар гэрээ, акт, нэхэмжлэлд үндэслэсэн эсэх, аккруэл суурь, зардлын хуваарилалтын зарчмыг хангахгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодитой илэрхийлэгдэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 70 дугаар зүйл 70.5-д “Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааны болон бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний зардлыг бүртгэхдээ аккруэл суурийг мөрдөж, зардлыг үүссэн хугацаанд нь тооцооны (өр төлбөрийн) дансаар дамжуулан бүртгэж байх.

5.2.2 Дансны авлагатай холбоотой

Илрүүлэлт:

2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар Пропертик ХХК-тай оффисын түрээсийн гэрээг 1 жилийн хугацаатай байгуулан гэрээний дагуу 7,776.0 мянган төгрөгийн барьцаа төлбөр төлсөн байна. Тайлант хугацаанд гэрээний хугацааг дахин 1 жилээр сунгаж түрээсийн гэрээ байгуулсан боловч 2025 оны 09 сарын 11-ний өдөр түрээсийн гэрээг цуцлах мэдэгдэл ирүүлж гэрээг цуцалсан байна. Гэвч Улаанбаатар Пропертик ХХК нь барьцаа төлбөрийг Төсөл хэрэгжүүлэх нэгж рүү шилжүүлээгүй авлага барагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 70 дугаар зүйл 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид ийм асуудал давтан гарахаас сэргийлж түрээсийн гэрээнд барьцаа төлбөр буцаан олголтын нөхцөл, хугацаа, хариуцлагыг тодорхой тусган, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, төсвийн тухай хуулийн дагуу үүссэн өр, авлагыг цаг тухай бүрт нь барагдуулж ажиллах

“Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
								Залруулсан		Залруулаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журамд төслийн нэгжийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийг хэрхэн нягтлан бодох бүртгэлд хүлээн зөвшөөрөх, тайлагнах талаарх нарийвчилсан зохицуулалт хийж өгөөгүй тул төсөл хэрэгжүүлэх нэгж нь татварын чөлөөлөлтийг зарим тохиолдолд үндсэн хөрөнгийн өртөгт шингээж, зарим тохиолдолд орлого болон өмчийн өөрчлөлтөөр бүртгэж тайлагнаж байсан ба 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/З тоот тушаалаар журмыг шинэчлэн баталж, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд үзүүлсэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн дүнг хөрөнгийн өртөг болон хөнгөлөлт чөлөөлөлтийн орлогоор хүлээн зөвшөөрөхгүй байх талаар тодорхой зааж өгсөн байна. Дээрх журмын шинэчилсэн зохицуулалтыг 2024 оны бүртгэлтэй харьцуулан үнэлэхэд нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийг үндсэн хөрөнгийн өртөгт шингээж бүртгэсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгийн үлдэгдэл 77,307.2 мянган төгрөгөөр, хуримтлагдсан элэгдэл 3,311.3 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн, Мөн гааль, НӨАТ-ын нийт 87,022.0 мянган төгрөгийн чөлөөлөлтийг өмнөх онд санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор, тайлант хугацаанд 77,307.2 мянган төгрөгийг өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капитал-аар бүртгэж тайлагнасан нь тайлан хоорондын логик уялдааг алдагдуулсан байна.	1	87,022.0	-	-	-	-	1	87,022.0	-	-
2	Оффисын түрээсийн өмнөх гэрээ цуцлагдаж Эко пропертиз ХХК-тай 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр 1 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулж гэрээний дагуу 11,760.0 мянган төгрөгийн барьцаа төлбөр төлсөн байна. Гэвч барьцаа төлбөрийг дансны авлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. Энэ тайлант хугацааны үр дүн, санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг буруу илэрхийлэх эрсдэлийг бий болгож байна.	1	11.760.0	-	-	-	-	1	11.760.0	-	-
	Дүн	2	98,782.0	-	-	-	-	2	98,782.0	-	-

“Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Улаанбаатар Пропертик ХХК-тай 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр оффисын түрээсийн гэрээг 1 жилийн хугацаатай байгуулан гэрээний дагуу 7,776.0 мянган төгрөгийн барьцаа төлбөр төлсөн байна. Тайлант хугацаанд гэрээний хугацааг дахин 1 жилээр сунгаж түрээсийн гэрээ байгуулсан боловч 2025 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр түрээсийн гэрээг цуцлах мэдэгдэл ирүүлж гэрээг цуцалсан байна. Гэвч Улаанбаатар Пропертик ХХК нь барьцаа төлбөрийг Төсөл хэрэгжүүлэх нэгж рүү шилжүүлээгүй авлага барагдаагүй байна.	1	7,776.0	-	-	-	-	1	7,776.0	-	-
2	Төсөл хэрэгжүүлэх нэгж нь хүн ам амьдрахад таатай хот, суурин газар (аймаг, сумын төв)-ыг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих, орон нутгийн ногоон хөгжлийн загвар, шинэчлэлийг хөхүүлэн дэмжих зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа боловч төслийн үйл ажиллагаа бүрэн жигдрээгүй, хүний нөөц, эд хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүй, төлөвлөлт, дотоод хяналт сул байгаагаас зээлийн санхүүжилтийг үр ашиггүй зарцуулах, хөдөлмөрийн зардлыг үндэслэлгүй нэмэгдүүлэх, төслийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан зэрэг зөрчил илэрлээ. Тухайлбал: Төслийн баланст 2 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байхад Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 210 тоот тушаалаар төслийн бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа жолоочийн орон тоог 3 байхаар тогтоосон нь ажлын ачаалал, хэрэгцээ шаардлагад нийцээгүй шийдвэр болсон байна. Тайлант хугацааны жолооч нарын ажлын гүйцэтгэлийг шалгахад 1 дүгээр жолооч 22 хоног, 2 дугаар жолооч 3 хоног, 3 дугаар жолооч 30 хоног албан томилолтоор ажилласан гэж жолоочийн тооцооны хуудсанд тусгасан боловч албан томилолтоос бусад өдрүүдэд авто тээврийн хэрэгслийг ашиглан үүргээ гүйцэтгэсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Гэтэл тайлант хугацаанд нийт ажлын 251 өдрийг бүтэн ажилласнаар тооцон цалин олгосон байна,	1	-	-	-	1	-	-	-	-	-
3	Ажлын байрны бодит хэрэгцээ шаардлага тодорхойгүй илүү жолооч ажиллуулснаас 30,360.0 мянган төгрөгийн цалингийн зардал, 3,795.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нийт 34,155.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гарган төсвийн сахилга бат алдагдсан байна,	1	34,155.0	-	-	1	34,155.0	-	-	-	-
4	Тайлант хугацаанд хамаарах үйл ажиллагааны зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний нийт 440,920.1 мянган төгрөгийн зардлыг	1	-	-	-	-	-	1	-	-	-

“Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
	тооцооны дансаар дамжуулан хуримтлуулж бүртгэлгүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь зардал хэзээ үүссэн, хэнээс авсан, ямар гэрээ, акт, нэхэмжлэлд үндэслэсэн эсэх, аккруэл суурь, зардлын хуваарилалтын зарчмыг хангахгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодитой илэрхийлэгдэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.										
Дүн		4	41,931.0	-	-	2	34,155.0	2	7,776.0	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1200/A0150061

Улаанбаатар хот

САГ - 2026/7/КА - СТА - ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлын байрны бодит хэрэгцээ шаардлага тодорхойгүй илүү жолооч ажиллуулснаас 30,360,000.0 /гучин сая гурван зуун жаран мянган/ төгрөгийн цалингийн зардал, 3,795,000.0 /гурван сая долоон зуу ерэн таван мянган/ төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нийт 34,155,000.0 /гучин дөрвөн сая нэг зуун тавин таван мянган/ төгрөгийн үр ашиггүй зардал гарган төсвийн сахилга бат алдагдсан байна.




Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 11 дүгээр зүйл 11.1.3-т "төсвийн зарлагын норм, норматив болон төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг тогтоох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Илүү жолооч ажиллуулсан зөрчлийг таслан зогсоож, цаашид жолоочийн орон тоог дахин хянаж, бүтэц орон тоог оновчтой тодорхойлох, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баярмагнай, Төслийн зохицуулагч М.Энх-амар, Санхүүгийн ажилтан Ч.Одонтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
УДИРДАХ ПАРТНЕР




Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ө.ИДШИНРИНЖИН

9006109
ATA14887
35250111

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Т-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325_SAG-46.Docx

1526181857



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1201/А0150061

Улаанбаатар хот

САГ - 2026 /1/НА - СТА - ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн балансанд 2 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байхад Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 210 дугаар тушаалаар төслийн бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа жолоочийн орон тоог 3 байхаар тогтоосон нь ажлын ачаалал, хэрэгцээ шаардлагад нийцээгүй шийдвэр болсон байна. Тайлант хугацааны жолооч нарын ажлын гүйцэтгэлийг шалгахад 1 дүгээр жолооч 22 хоног, 2 дугаар жолооч 3 хоног, 3 дугаар жолооч 30 хоног албан томилолтоор ажилласан гэж жолоочийн тооцооны хуудсанд тусгасан боловч албан томилолтоос бусад өдрүүдэд авто тээврийн хэрэгслийг ашиглан үүргээ гүйцэтгэсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Гэтэл тайлант хугацаанд нийт ажлын 251 өдрийг бүтэн ажилласнаар тооцон цалин олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 11 дүгээр зүйл 11.1.3-т "төсвийн зарлагын норм, норматив болон төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг тогтоох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, жолооч нарын ажлын гүйцэтгэлийг авто тээврийн хэрэгслийн ашиглалтын бүртгэл, замын хуудас, ажилласан цагийн бүртгэл, бодит гүйцэтгэлтэй уялдуулан цалинжуулж байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төслийн зохицуулагч М.Энх-амар, Санхүүгийн ажилтан Ч.Одонтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
УДИРДАХ ПАРТНЕР

B. M.

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

O. S. J.

О.ИДШИНРИНЖИН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\20260325 SAG-46.Docx

1526181839